



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 609

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа газруудын Шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 53,394,600.00 (тавин гурван сая гурван зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ бүхий 4 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, хавсралтад заасан харьяа Шүүхийн тамгын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 12 дугаар сарын 12 өдрийн  
609 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА, ХАРЬЯА НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАГААР ХУДАЛДАХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Автомашин, улсын болон хөдөлгүүр, арлын дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
1	Завхан аймаг дахь Шүүхийн тамгын газар	Ланд-80, 92-87 ЗАА, HDJ810039657	ш	1	1993 / 2010	288,698	23,210,000.00	23,210,000.00	-	2,000,000.00
2	Сүхбаатар аймаг дахь Шүүхийн тамгын газар	Хьюндай Старикс, 64-76 УБЦ, КМННWR81НР3U5658 45	ш	1	2003/2007	112,620	3,602,400.00	3,602,400.00	-	1,500,000.00
3	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	Исузу Бигхорн, 77-69 СЗУ, UBS73GW7211384	ш	1	2000/2010	149,236	16,495,000.00	16,495,000.00	-	2,500,000.00
4	Шүүхийн ерөнхий зөвлөл	Хьюндай Грасе, 75-82 УБС, КМJFD37ARTU33742 9	ш	1	1996 / 2013	200,000	10,087,200.00	10,087,200.00	-	1,000,000.00
Нийт дүн							53,394,600.00	53,394,600.00	-	7,000,000.00

/төгрөгөөр/